



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/66

Пионер толгой

Бэлчээр хашиж хамгаалах ажилд хяналт тавих,  
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66,1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ны 10/02 тоот тогтоолын 02 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтанд тусгагдсан Цэнгэл 1 дүгээр багт бэлчээр хашиж хамгаалах ажилд хяналт тавьж, хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Р.Гантулга	Тамгын газрын дарга
Гишүүд	М.Ариунсан	Хөдөө аж ахуйн тасгийн дарга
	Б.Няммэший	Нягтлан бодогч
	Ш.Нархүү	Байгаль орчны улсын байцаагч
Нарийн бичгийн дарга	Б.Лувсанширэв	Цэнгэл 1 дүгээр багийн Засаг дарга

2.Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, үе шатны ажлын хуваарийн дагуу гүйцэтгэлд хяналт тавьж, шалгаж, акт үйлдэн хүлээн авахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа) –д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

